



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/70

Чингис хот

Халдвар хамгаалалтын дэглэмийг  
мөрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн зөвхөн албан ажлын зайлшгүй шаардлагаар нэвтрэх тохиолдолд халууныг хэмжиж, амны хаалт зүүлгэж, гарыг ариутган нэвтрүүлж халдвар хамгаалалтын дэглэмийг мөрдүүлж ажиллахыг Хэнтий нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-ын дарга /Баяржаргал/-д үүрэг болгосугай.

2. Байгууллагын тусгаарлах байрны бэлэн байдлыг хангаж, халдвар, хамгаалалт, ариутгалын нөөц бүрдүүлэхийг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

3. Халдвар, хамгаалалтын дэглэмийг чанд сахиж, коридор, өрөө тасалгаагаар сэлгүүцэхгүй байхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Ж.Гантулга/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030370